



Нийслэлийн Орон сууцны бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2022 оны ..07.. дугаар сарын ..08.. -ны өдрийн A/УЗ. дугаар тушаалын 14 дүгээр хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан үндэслэл

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Хууль тогтоомжийн нэр огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нийслэлийн Орон сууцны бодлогын газар

Нэгжийн нэр:

Бодлогын хэрэгжилтийн хэлтэс

Албан тушаалын нэр:

Дэд бүтцийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-5

Ажлын цаг:

Ажлын өдөр 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Нийслэлийн өмчийн 1-р байр, Амарын гудамж, Соёлын төв өргөө Г корпус, 11 давхар

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Салбарын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, шинээр баригдах барилга, байгууламж орон сууцны хорооллын нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамжийг шийдвэрлэх, нэмэгдүүлэх, орон сууцны дэд бүтцийг хөгжүүлэх эрх зүйн орчин, норм нормативын баримт бичгийг боловсронгуй болгоход санал оруулах чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг нэгжийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Салбарын болон бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх;
2. Гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, дахин төлөвлөн барилгажуулах инженерийн дэд бүтэцтэй амины сууц болон орон сууцны хороолол болгон хөгжүүлэх ажлыг төлөвлөх, орон сууцны дэд бүтцийг хөгжүүлэх эрх зүйн орчин, норм нормативын баримт бичгийг боловсронгуй болгоход санал оруулах;
3. Байгууллага нэгжийн үйл ажиллагаанд шаардлагатай дэмжлэг үзүүлж, хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах-Х Шийдвэрлэх -Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	<p>1. Салбарын болон бусад хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангаж биелэлтийг тайлагнах;</p> <p>2. Салбарын хууль, тогтоомж, бусад эрх зүйн актын төсөлд газрын чиг үүрэгт хамаарах асуудлаар санал өгөх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад гарч буй асуудлыг шийдвэрлүүлэх, хууль журамд оруулах талаар санал боловсруулан удирдах албан тушаалтанд танилцуулах.</p>	Хууль, тогтоомжийг хэрэгжүүлсэн, биелэлтийг тайлагнасан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	<p>1. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд нийгмийн болон инженерийн дэд бүтцээр хангасан орон сууцны хорооллыг барьж байгуулахад шаардлагатай инженерийн шугам сүлжээний хүчин чадал, хүртээмжийн судалгаа гаргах, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, улс, нийслэлийн төсөвт саналыг бэлтгэх;</p> <p>2. Нийслэлийн гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах, бие даасан болон хэсэгчилсэн инженерийн хангамжаар хангах дэд бүтцийг бий болгох ажлыг холбогдох байгууллагуудтай хамtran зохион байгуулах;</p> <p>3. Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөлтийн дагуу гэр хорооллын дахин төлөвлөлтийн байршилд баригдах</p>	<p>Судалгаа нэгтгэгдсэн байна.</p> <p>Холбогдох байгууллагуудтай хамtran ажилласан байна.</p> <p>Санал боловсруулсан</p>	Г Г Г



	<p>сургууль, цэцэрлэгийн газар чөлөөлөлтийн төлөвлөгөөнд тусгах саналыг холбогдох байгууллагуудтай хамтран уялдуулан шийдвэрлүүлэхээр санал боловсруулах, тооцоо судалгаа гаргах;</p> <p>4. Орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор хэрэгжсэн, хэрэгжих буй төсөл, хөтөлбөрийн хүрээнд баригдсан орон сууц, инженерийн шугам сүлжээний бүртгэл мэдээллийн нэгдсэн цахим сан үүсгэх, түүний удирдах, ашиглах, байнгын тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, нууцлалтын найдвартай байдлыг хангах;</p> <p>5. Байгаль орчинд ээлтэй, сэргээгдэх эрчим хүчний шинэлэг технологи бүхий орон сууц, дэд бүтцийн оновчтой шийдэл бүхий орон сууцны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор олон улсын туршлага судлах, солилцох, мэргэжлийн түвшинд судалгаа хийх, судалгааны үр дүнг танилцуулах ажлыг зохион байгуулах.</p>	байна.	
	<p>1. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, тайлагнах;</p> <p>2. Байгууллагын дүрэм, дотоод журам, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд мөрдөн, ажлын цаг ашиглалт, хөдөлмөрийн сахилга батыг сахин ажиллах;</p> <p>3. Удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, мэдээ мэдээллийг цаг хугацаанд нь тайлагнах;</p> <p>4. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, журам, стандартын дагуу албан хэргийг хөтлөх, архивын баримтыг хугацаанд нь шилжүүлэх;</p> <p>5. Байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж, төрийн болон байгууллага хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг чандлан хадгалах.</p>	<p>Бүртгэл мэдээллийн нэгдсэн цахим сантай болсон байна.</p> <p>Хэрэгжилт хангагдсан байна.</p> <p>Хэрэгжилт хангагдсан байна.</p> <p>Төрийн албаны стандарт хангагдсан байна.</p> <p>Тухай бүр тайлагнасан байна.</p> <p>Холбогдох журмын дагуу архивт хүлээлгэн өгсөн байна.</p> <p>Нууц хадгалсан, ил тод байдлыг хангасан байна.</p>	<p>Г</p> <p>Г, Т</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p> <p>Г</p>
3 дугаар зорилтын хүрээнд			

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй
Мэргэжил	- цахилгааны инженер /071309/; - барилгын инженер /073204/;



	- архитектур, хот төлөвлөлт /0731/.
Мэргэшил	Төрийн албаны богино болон дунд хугацааны сургалтад хамрагдсан байх.
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх ур чадвар <ul style="list-style-type: none"> - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг нэгтгэн дүгнэх, санал зөвлөмж боловсруулах; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх; - гүйцэтгэж буй ажлын явц үр дүнг тайлагнах; - тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийж, нөхцөл байдал, хувилбарыг тодорхойлох чадвартай байх; - бусад.
	Асуудал шийдвэрлэх ур чадвар <ul style="list-style-type: none"> - албан үүргийнхээ дагуу хариуцах ажил үүргийг хууль, тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн гүйцэтгэх; - үндэсний язгуур эрх ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх; - хууль тогтоомжийн хүрээнд асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, эрсдэлийг тооцох, хариуцах; - хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдлийг гаргах; - албан тушаалын чиг үүргээ хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид гүйцэтгэх; - үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах; - бусад.
	Багаар ажиллах ур чадвар <ul style="list-style-type: none"> - өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч харилцааг бий болгох; - маргаантай асуудалд хүлээцтэй, нийцтэй ханддаг байх; - бүтээлч санаачилгатай ажиллах; - бусад.
	Бусад чадвар ур <ul style="list-style-type: none"> - компььютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийн дэвшилтээ аргыг ашиглах; - албан ажлын чиг үүргийнхээ дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээлэл өгөх чадвартай байх; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалт сайтай байх; - байгууллагын болон хувь хүний нууцыг хадгалах; - төрийн албан хэрэг хөтлөлт, бичиг хэрэг, монгол хэл, найруулга зүйн чадвартай байх; - харилцааны ур чадвартай байх; - англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЬЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:

Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга



<u>Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u> Байхгүй	<u>Бусад харилцах субъект:</u> <ul style="list-style-type: none"> - яам, агентлагийн холбогдох албан тушаалтан; - нутгийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагын холбогдох албан тушаалтан; - төрийн болон төрийн бус байгууллага; - иргэн, хуулийн этгээд.
---	---

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
<p>Албан тушаал: ЗАХИРГАА САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА /П.ДАШРИНЧИН/ 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдөр</p> 	<p>Байгууллагын нэр: ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ Шийдвэрийн огноо: 22 05 18 Дугаар: 370</p>

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

<u>Байгууллагын нэр:</u> НИЙСЛЭЛИЙН ОРОН СУУЦНЫ БОДЛОГЫН ГАЗАР Шийдвэрийн огноо: 2022.07.08 Дугаар: 4/13 (тамга/тэмдэг) ДАРГА..... 2022 оны 07 дугаар сарын 08-ны өдөр		
--	---	---